



International Organization for Migration (IOM)

The UN Migration Agency

DTM

ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ТАНДАХ – МОНГОЛ УЛС ДАХЬ ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДАЛ

СУУРЬ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН: ӨМНӨГОВЬ АЙМАГ

2-р шат, 2018 он



IOM Development Fund

DEVELOPING CAPACITIES IN MIGRATION MANAGEMENT

Зураг: Ёндонжамц Нямдаваа

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУУРЬ ҮНЭЛГЭЭ

2018 оны 4-6 сар

ОРШИЛ

Монголчууд эртнээс нааш урт, богино хугацаагаар нүүж, шилжиж, хөдөлгөөнтэй амьдарч ирсэн уламжлалтай. Тиймдээ ч, богино хугацааны (< 3 сараас) шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг системтэй байдлаар цуглуулдаггүй. Гэвч, сүүлийн үед Улаанбаатар руу чиглэсэн шилжилт нэмэгдэж байгаа нь уур амьсгалын өөрчлөлт зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж байгаа бөгөөд үүнд эрүүл мэнд, боловсролын сайн үйлчилгээ хүртэх, ажил эрхлэлтийн илүү сайн боломж нөхцөлтэй болох хүсэл, шалтгаан голлож байна¹.

Монгол орон газар зүйн өвөрмөц байршилтай, хөдөөгийн хүн ам нь мал аж ахуйн салбараас ихээхэн хамааралтай байдаг зэргээс уур амьсгалын өөрчлөлт, өвөл цагийн хүндрэлд өртөмтгий байдаг. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан ган, зуд² ын давтамж нэмэгдснээс хөдөөгүүр хүмүүсийн амьжиргаа залгуулах боломж хомсдож орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ихсэх хандлагатай байна.

Хэрэв энэ хандлага үргэлжилсээр байвал, давтамж нь өсөн нэмэгдэж буй гамшгийн нөлөөгөөр орон нутгаас Улаанбаатарыг зорих шилжин суурьшигчийн тоо эрчимтэйгээр өсөн нэмэгдэнэ. Нийслэлийн захиргаа шинээр ирж буй шилжин суурьшигчийг байршуулж суурьшуулахад ихээхэн бэрхшээлтэй тулгарсаар байна. Гамшгийн бэлэн байдлыг хангах, онцгой байдлын үед зорилтот хариу арга хэмжээ авах зорилгоор Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ) нь тухайн газар дээр байгаа хүний тоог мэдэх ба хүн амын шилжилт хөдөлгөөний талаархи тодорхой мэдээлэл авах шаардлагатай байгаа юм.

Тус оронд гамшигт үзэгдэл нэмэгдэж байгааг үндэслэн Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), Монгол Улс дахь гамшгийн бэлэн байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор шилжилт хөдөлгөөнийг тандах цогц мэдээллийн системийг бий болгох ажлыг эхлүүлсэн. Энэхүү системийг нэвтрүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөний талаар Шилжин суурьшилтын нөхцөл байдлын үнэлгээ (ШСБНҮ) хийх аргаар мэдээллийг цуглуулж боловсруулан, гамшгийн бэлэн байдлыг хангах, онцгой байдал үүссэн үед хэрэглэх боломж бүхий мэдээллийн сан үүсгэж байна.

ШСБНҮ нь шилжин суурьшиж буй хүн амын богино хугацааны нүүдэл, шилжин суурьшилтын талаарх мэдээллийг цуглуулж, боловсруулж байгаагаараа онцлог юм.

АРГАЧЛАЛ

ОБЕГ-аас хэрэгжүүлэх мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл, стратеги нь ШСБНҮ-ийн дэлхийн аргачлал дээр тулгуурласан бөгөөд Монголын нөхцөл байдал, шилжин суурьшилтийн хэв маягт тохирсон юм. Цуглуулсан мэдээллийн өөр өөр түвшин нь Монгол улсын хүн амын цогц дүр төрхийг харуулахад хувь нэмрээ оруулна.

Энэхүү суурь үнэлгээнд ОУШХБ нь хүн амыг шилжин суурьшилтийн төрхөөр нь хоёр бүлэгт ялгадаг: оршин суугчид (тухайн байршил/газарт амьдарч буй аливаа хүн), шилжин суугч хүн ам (1-3 сарын дотор сумаас гарсан/сум руу шилжин ирсэн хүмүүс).

ОБЕГ, ОУШХБ - ын тодорхойлолтоор шилжин суугч гэдэг нь хэн нэгэн өөрийн хүслээр эсвэл ямар нэгэн гадны хүчин зүйлээс шалтгаалан нэг газраас нөгөө газар руу түр хугацаагаар, улирлын хугацаагаар, эсвэл бүрмөсөн шилжин суурьшихыг хэлнэ. Энэ нь малчдын богино хугацааны нүүдлээс эхлэн иргэдийн урт хугацаагаар, бүрмөсөн шилжин суух зэрэг шилжих хөдөлгөөний бүх хэлбэрийг хамарна.

Байршлын үнэлгээг нийслэл Улаанбаатарыг оролцуулалгүйгээр засаг захиргааны хоёрдахь шатны түвшинд (сум) явуулсан. ОУШХБ-тай зөвлөлдсөний үндсэн дээр ОБЕГ-аас олж тодорхойлсон гол мэдээлэгчтэй ярилцлага хийж, тухайн орон нутгийн хүн амын багцаа тоо, нүүж ирсэн болон нүүж явсан иргэдийн тоо, хөдөлгөөнд оролцсон сар, хаанаас хаашаа ямар шалтгаанаар нүүсэн талаар мэдээлэл цуглуулсан.

Энэхүү үнэлгээг 330 гаруй сумдад (Улаанбаатар орооогүй) явуулсан¹².

Энэхүү тайланд зөвхөн Өмнөговь аймаг дахь хүн амын шилжих хөдөлгөөнд хийсэн дүн шинжилгээг танилцуулна.

¹ Монгол Улсын Их Сургууль (МУИС), Нэгдсэн Үндэсний Байгууллагын Их Сургууль – Мерит болон Олон Улсын Шилжих Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ) (2018 он). “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож зохицуулах нь.”

² Зуд гэдэг нь Монгол Улсад тохиолддог өвөрмөц, удаан хугацаагаар үргэлжилдэг улирлын чанартай байгалийн гамшиг юм. Энэ нь зундаа ган болсны дараа өвөл, хаврын улиралд цаг агаарын нөхцөл байдал эрс доройтож, ус, бэлчээрийн дутагдал гарч их хэмжээний малын хорголдолд хүргэхийг хэлнэ



Зураг: Ёндонжамц Нямдаваа

ТОВЧ ТОЙМ

Өмнөговь бол Монгол Улсын өмнө зүгт, Говийн нутагт орших Монголын нэг аймаг юм. Өмнөговь бол Монгол Улсын хамгийн том нутаг дэвсгэртэй аймаг. Аймгийн төв нь Даланзадгад, нутаг дэвсгэрийн нийт талбай 165,380 км². Засаг захиргааны хувьд тус аймаг 15 сумд хуваагддаг. Тус аймаг эрдэс баялаг ихтэй, түүнчлэн алт, зэс, нүүрсний ордтой. Хөдөө аж ахуйн салбарын ач холбогдол бага. Оюу Толгой гэдэг томоохон зэсийн уурхай Ханбогд сумд байрладаг, харин нүүрсний Таван Толгой орд Цогтцэций сумд байдаг.



ГОЛ ДҮГНЭЛТ

Өмнөговь аймгаас 2018 оны 4-6 сард нийт 967 хүн нүүж явсан.

Өмнөговь аймгаас нүүж явсан нийт иргэдийн тал хувь нь гурван сумаас нүүсэн байна: Даланзадгад, Цогтцэций, Цогт-Овоо.

Өмнөговь аймгаас нүүж явсан иргэдийн тоо 4-6 сарын хооронд тогтмол өссөн. Нийт нүүсэн иргэдээс 27 хувь нь 4-р сард нүүсэн бол, 6-р сард энэ хувь хэмжээ 38 хувь болж нэмэгдсэн байна.

Нийт нүүж явсан иргэдийн 35 хувь нь Цогтцэций болон Ханбогд сум руу явсан.

Говьд орших Цогтцэций сум, Ханбогд сум нь Өмнөговь аймгийн уул уурхайн бүс нутаг ба энд уурхайн үйл ажиллагаа сүүлийн үед огцом өсч байна.

Оюу Толгойн томоохон зэсийн уурхай Ханбогд сумд байрладаг, харин нүүрсний Таван Толгой орд Цогтцэций сумд байдаг. Эдгээр хоёр уурхай дэлхийн хамгийн том уурхайнуудын тоонд ордог. Энэ хоёр уурхай нь Өмнөговь аймгаас хүн ам татах томоохон хүчин зүйлс болох ба түр зуурын ажлын байр хайх иргэд уурхай руу олноор нүүж ирдэг гэж дүгнэж болохоор байна.



НОРШИЛ


2018 оны 4-6 сарын хооронд нийт 967 иргэд Өмнөговь аймгаас нүүж явсан байна.

Өмнөговь аймгаас нүүж явсан нийт иргэдийн тал хувь нь гурван сумаас нүүсэн байна: Даланзадгад, Цогтцэций, Цогт-Овоо.


Хамгийн цөөн иргэд нүүсэн нь Мандал-Овоо, Ноён сумд гарлаа.

Доорх газрын зураг дээр Өмнөговь аймгаас нүүж явсан иргэдийн тоог сумдаар харуулж байна.

Зураг 1: Өмнөговь аймгаас 2018 оны 6-4 сард нүүсэн иргэдийн тоо, сумаар



Газрын зураг 1: Өмнөговь аймгаас 2018 оны 6-4 сард нүүсэн иргэдийн тоо, сумаар.




Энэ газрын зураг зөвхөн тодруулах зорилготой.

Газрын зураг дээрх нэр, хил хязгаарыг ОУШХБ-ын зүгээс албан ёсоор сайшаасан эсвэл хүлээн зөвшөөрсөн гэж ойлгохгүй.

ХЭДЭН ХҮН ХААНААС НҮҮСЭН БЭ?

Өмнөговь аймгаас нүүж явсан иргэдийн тоо 4-6 сарын хооронд тогтмол өссөн. Нийт нүүсэн иргэдээс 27 хувь нь 4-р сард нүүсэн бол, 6-р сард энэ хувь хэмжээ 38 хувь болж нэмэгдсэн байна.


Зураг 1: Өмнөговь аймгаас нүүж явсан иргэдийн хувь, сараар.



Өмнөговь аймгаас нүүсэн иргэдийн хувьд өөр аймаг руу нүүх эсвэл Улаанбаатар руу нүүхээс илүү аймгийнхаа өөр сум рүү нүүх нь илүү байв.

Нийт нүүсэн иргэдийн 70 хувь нь Өмнөговь аймгийн өөр сум руу, 22 хувь нь Улаанбаатар руу, үлдсэн 9 хувь нь өөр аймаг руу (ихэвчлэн Дорноговь, Дундговь) тус тус нүүсэн байна.


Зураг 2: Өмнөговь аймгаас 2018 оны 6-4 сард нийслэл хот/өөр аймаг/Өмнөговь аймгийн өөр сум руу нүүж явсан иргэдийн хувь.



5-6 сард, Өмнөговь аймгийн өөр сум руу нүүх иргэдийн хувь өссөн.

4-6 сард Өмнөговь аймгаас нүүсэн нийт иргэдийн 56 хувь нь Өмнөговь аймгийн өөр сум руу нүүсэн ба энэ хувь нь 6-р сард 74 хувь болж өслөө.

Зураг 3: Өмнөговь аймгаас 2018 оны 6-4 сард нийслэл хот/өөр аймаг/Өмнөговь аймгийн өөр сум руу нүүж явсан иргэдийн хувь, нүүсэн сараар.



Очих газар нь нүүсэн сумаас хамааран нилээд хэлбэлзэж байв.

Цогтцэций сумаас нүүсэн иргэд Улаанбаатар руу явсан.

Цогт-Овоо сумаас нүүсэн иргэд Дорноговь аймгийн Мандах сум руу (4-р сард) эсвэл Даланзадгад сум руу (5-6 сард) явсан.

Аймгийн төв Даланзадгадаас нүүсэн иргэд ихэвчлэн Цогтцэций сум руу (5-р сард) эсвэл Ханбогд сум руу (4-р сард ба 6-р сард) нүүж явсан байна.


Нийт нүүсэн иргэдийн тал орчим хувь нь Цогтцэций эсвэл Ханбогд сум руу нүүсэн.

Говьд орших Цогтцэций сум, Ханбогд сум нь Өмнөговь аймгийн уул уурхайн бүс нутаг ба энд уурхайн үйл ажиллагаа сүүлийн үед огцом өсч байна.

Оюу Толгойн томоохон зэсийн уурхай Ханбогд сумд байрладаг, харин нүүрсний Таван Толгой орд Цогтцэций сумд байдаг. Эдгээр хоёр уурхай дэлхийн хамгийн том уурхайнуудын тоонд ордог. Энэ хоёр уурхай нь Өмнөговь аймгаас хүн ам татах томоохон хүчин зүйлс болох ба түр зуурын ажлын байр хайх иргэд уурхай руу олноор нүүж ирдэг гэж дүгнэж болохоор байна.



Газрын зураг 2: Даланзадгад, Цогтмэний, Цогт-Овоо сумаас нүүсэн иргэдийн очих газар.



Энэ газрын зураг зөвхөн тодруулах зорилготой.

Газрын зураг дээрх нэр, хил хязгаарыг ОУШХБ-ын зүгээс албан ёсоор сайшаасан эсвэл хүлээн зөвшөөрсөн гэж ойлгохгүй.